



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: АХГ-2022/01/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261628 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Аудитор: О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага.....	10
3.5.3 Урьдчилгаа	11
3.5.4 Үндсэн хөрөнгө	11
3.5.5 Засгийн газрын хувь оролцоо	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Харьяа байгууллагууд.....	15
4.2.1 Зардлын данстай холбоотой асуудал.....	15
4.2.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал	15
4.2.3 Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой асуудал.....	16
4.3 Зөвлөмж	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА А.ЭНХМАНЛАЙ ТАНАА

2022.03.25 № 07/407
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,056,743.0	3,800,488.7
МӨНГӨН ХӨРӨНГӨ	91,679.7	325,144.6
АВЛАГА	1,055,311.6	1,142,790.6
УРЬДЧИЛГАА	40,337.3	449,753.0
БАРАА МАТЕРИАЛ	1,869,414.4	1,882,800.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,467,985.6	16,144,009.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,467,985.6	16,144,009.4
Биет хөрөнгө	14,750,386.6	14,609,872.7
Биет бус хөрөнгө	1,717,599.0	1,534,136.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,524,728.6	19,944,498.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР	204,232.7	197,432.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	204,232.7	197,432.9
Өглөг	4,510.9	15,849.5
Урьдчилж орсон орлого	199,721.8	181,583.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,320,495.9	19,747,065.2
Засгийн газрын хувь оролцоо	9,666,173.7	9,656,917.1
Засгийн газрын оруулсан капитал	8,778,951.3	8,791,755.3
Хуримтлагдсан үр дүн	9,654,322.2	10,090,148.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	887,222.3	865,161.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,524,728.6	19,944,498.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	54,703,133.1	38,861,255.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,288,441.5	8,435,932.1
Нийтлэг татварын бус орлого	9,288,441.5	8,435,932.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	45,414,691.6	30,425,323.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	52,841,618.8	38,421,511.9
УРСГАЛ ЗАРДАЛ	52,841,618.8	38,421,511.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,878,546.8	27,980,911.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	11,933,527.9	11,993,011.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,545,033.9	1,580,687.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	722,821.5	743,459.0
Хангамж, бараа материалын зардал	1,274,869.7	1,067,005.8
Нормативт зардал	11,535.9	12,228.7
Эд хогшил, урсгал засварын зардал	210,500.7	217,420.7
Томилолт, зочны зардал	251,969.7	260,604.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,174,346.3	8,647,220.6
Бараа үйлчилгээний бусад зардал	3,753,941.3	3,459,272.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,963,072.0	10,440,600.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,861,514.3	439,743.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,964.1	75,978.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,810,550.2	363,765.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	53,118,272.0	39,375,892.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,879,747.3	7,574,646.1
Нийтлэг татварын бус орлого	6,879,747.3	7,574,646.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,238,524.7	31,801,246.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,163,080.8	38,053,858.5
УРСГАЛ ЗАРДАЛ	51,163,080.8	38,053,858.5
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,960,138.8	27,437,352.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	11,960,756.2	12,060,274.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,596,588.6	1,606,212.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	624,099.0	643,448.8
Хангамж, бараа материалын зардал	751,009.8	673,255.4
Нормативт зардал	23,317.8	21,862.7
Эд хогшил, урсгал засварын зардал	269,637.5	343,785.1
Томилолт, зочны зардал	278,438.2	263,616.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,048,488.6	9,852,979.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1,407,803.3	1,971,917.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,202,942.0	10,616,505.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,955,191.2	1,322,034.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,110,600.4	1,088,569.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,110,600.4	1,088,569.1
Дотоод эх үүсвэрээр	2,110,600.4	1,088,569.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-2,110,600.4	-1,088,569.1
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-155,409.2	233,464.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	247,088.9	91,679.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	91,679.7	325,144.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,501,073.2	-	17,501,073.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(21,637.3)	-	(21,637.3)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,479,435.9	-	17,479,435.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	30,509.8	-	30,509.8
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Тайлант үеийн үр дүн	1,810,550.2	-	1,810,550.2
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,320,495.9	-	19,320,495.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	72,060.5		72,060.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,392,556.4		19,392,556.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(22,060.5)		(22,060.5)
Өмчид гарсан өөрчлөлт	12,804.0		12,804.0
Тайлант үеийн үр дүн	363,765.2		363,765.2
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,747,065.1		19,747,065.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,243,671.0	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,239,458,027.0	17,013,765,565.0	225,692,462.0	98.7
III. УРСГАЛ ЗАРДАЛ	17,239,458,027.0	17,013,765,565.0	225,692,462.0	98.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,878,447,027.0	16,668,474,895.7	209,972,131.3	98.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	11,640,018,900.0	11,637,143,094.2	2,875,805.8	100.0
Үндсэн цалин	8,013,647,200.0	8,137,069,443.6	(123,422,243.6)	101.5
Нэмэгдэл цалин	2,925,311,400.0	2,675,776,855.2	249,534,544.8	91.5
Унаа хоолны хөнгөлөлт	369,190,400.0	528,759,567.7	(159,569,167.7)	143.2
Урамшуулал	-	21,424,793.1	(21,424,793.1)	
Гэрээт ажлын цалин	331,869,900.0	274,112,434.6	57,757,465.4	82.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,567,951,300.0	1,543,649,435.3	24,301,864.7	98.5
Тэтгэврийн даатгал	1,103,372,700.0	1,110,425,749.6	(7,053,049.6)	100.6
Тэтгэмжийн даатгал	116,144,600.0	111,211,643.7	4,932,956.3	95.8
ҮОМШӨ-ний даатгал	92,916,000.0	86,625,266.6	6,290,733.4	93.2
Ажилгүйдлийн даатгал	23,229,000.0	21,445,849.5	1,783,150.5	92.3
Эрүүл мэндийн даатгал	232,289,000.0	213,940,925.7	18,348,074.3	92.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	738,151,127.0	643,801,767.9	94,349,359.1	87.2
Гэрэл, цахилгаан	57,766,697.0	46,483,380.4	11,283,316.6	80.5
Түлш, халаалт	389,927,100.0	353,526,355.5	36,400,744.5	90.7
Цэвэр, бохир ус	48,479,930.0	45,666,644.0	2,813,286.0	94.2
Байрны түрээс	241,977,400.0	198,125,388.0	43,852,012.0	81.9
Хангамж, бараа материалын зардал	401,926,000.0	489,574,555.0	(87,648,555.0)	121.8
Бичиг хэрэг	132,080,800.0	135,977,089.1	(3,896,289.1)	102.9
Тээвэр, шатахуун	198,928,100.0	259,271,024.0	(60,342,924.0)	130.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,781,000.0	38,156,360.1	(5,375,360.1)	116.4
Ном, хэвлэл	-	15,000.0	(15,000.0)	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	614,100.0	386,300.0	227,800.0	62.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,522,000.0	55,768,781.8	(18,246,781.8)	148.6
Нормативт зардал	10,507,600.0	6,817,906.0	3,689,694.0	64.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,507,600.0	6,817,906.0	3,689,694.0	64.9
Эд хогшил, урсгал засварын зардал	56,015,900.0	51,839,815.4	4,176,084.6	92.5
Багаж, техник, хэрэгсэл	30,253,800.0	21,055,445.4	9,198,354.6	69.6
Тавилга	-	5,000,000.0	(5,000,000.0)	
Урсгал засвар	25,762,100.0	25,784,370.0	(22,270.0)	100.1
Томилолт, зочны зардал	273,149,000.0	204,754,983.0	68,394,017.0	75.0
Дотоод албан томилолт	273,149,000.0	204,754,983.0	68,394,017.0	75.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,621,905,100.0	1,586,803,728.4	35,101,371.6	97.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,175,062,000.0	1,155,551,077.2	19,510,922.8	98.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,197,100.0	4,309,100.0	888,000.0	82.9
Даатгалын үйлчилгээ	11,800,500.0	17,003,775.0	(5,203,275.0)	144.1
Тээврийн хэрэгслийн татвар	3,002,500.0	3,384,190.0	(381,690.0)	112.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,239,100.0	1,251,400.0	(12,300.0)	101.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,770,000.0	25,009,732.2	760,267.8	97.0
Газрын төлбөр	604,300.0	1,368,124.0	(763,824.0)	226.4

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	399,229,600.0	378,926,330.0	20,303,270.0	94.9
Бараа үйлчилгээний бусад зардал	568,822,100.0	504,089,610.5	64,732,489.5	88.6
Бараа үйлчилгээний бусад зардал	563,232,700.0	502,964,610.5	60,268,089.5	89.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,589,400.0	1,125,000.0	4,464,400.0	20.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	361,011,000.0	337,786,369.4	23,224,630.7	93.6
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911,100.0	1,911,100.0	-	100.0
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад		1,883,142.9	(1,883,142.9)	
Бусад урсгал шилжүүлэг	359,099,900.0	333,992,126.4	25,107,773.6	93.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	55,996,200.0	65,814,447.1	(9,818,247.1)	117.5
Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, урамшуулал	-	2,700,000.0	(2,700,000.0)	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	278,716,000.0	227,234,194.3	51,481,805.7	81.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	24,387,700.0	38,243,485.0	(13,855,785.0)	156.8
IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,504,300.0	(7,504,300.0)	
Бусад хөрөнгө	-	7,504,300.0	(7,504,300.0)	
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,239,458,027.0	17,012,373,565.0	227,084,462.0	98.7
Улсын төсвөөс санхүүжих	16,381,830,700.0	16,245,254,664.2	136,576,035.8	99.2
Улсын төсвөөс санхүүжих	2,877,451,100.0	2,876,956,422.3	494,677.7	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	13,504,379,600.0	13,368,298,241.9	136,081,358.1	99.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	707,627,327.0	617,118,900.8	90,508,426.2	87.2
Орон нутгийн төсвөөс	707,627,327.0	617,118,900.8	90,508,426.2	87.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	150,000,000.0	150,000,000.0	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000,000.0	150,000,000.0	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,851,671.0		

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгөн хөрөнгийн 2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл		87,436.1
ОРЛОГЫН ДҮН		7,006,847.4
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		912,205.5
ЗГНХ,ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		125,370.3
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,325,017.4
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,514,781.7
Төсвийн урамшуулал		129,472.4
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		6,984,717.4
А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		6,476,643.6
1. Бараа үйлчилгээний зардал		4,829,564.7
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		397,020.2
Үндсэн цалин		134,975.3
Нэмэгдэл		1,952.0
Урамшуулал		14,129.2
Гэрээт ажлын хөлс		245,963.7
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		62,563.1
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		4,369,981.4
Цэвэр бохир ус		1,770.0
Бичиг хэрэг		63,633.9
Тээвэр, шатахуун		98,524.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,638.4
Ном, хэвлэл		5,250.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал		150.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		16,291.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл		15,044.8
Багаж, техник, хэрэгсэл		329,628.6
Тавилга		26,770.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		8,415.5
Урсгал засвар		309,650.9
Дотоод албан томилолт		58,011.5
Зочин төлөөлөгч хүлээн авах		850.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний		1,832,927.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		538.4
Даатгалын үйлчилгээ		1,260.0
Тээврийн хэрэгслийн татвар		392.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,355.1
Газрын төлбөр		86.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		11,053.1
Бараа үйлчилгээний бусад зардал		1,554,471.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		32,267.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,647,078.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		24,044.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		39,800.3
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		150.0
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		266,701.6
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		993,629.9
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		322,753.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		508,073.9
Барилга байгууламж		60,000.0
Их засвар		158,634.7
Тоног төхөөрөмж		229,694.2
Бусад хөрөнгө		59,745.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		109,566.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Үндэсний аудитын газрын аудитор О.Баярмаа, М.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитын менежер Д.Энхдалай, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, МУЕА-ын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/456 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, технологийн орон зайн мэдээллийн менежментийн талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-аас 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь БХБС-ын 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 63 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт зардал 16,532.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 165.3 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 419.7 сая төгрөгөөр буюу 2.15 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 325.1 сая төгрөг болж, өмнөх оноос 233.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	35,436.9	3,858.8	(31,578.1)
Банканд байгаа бэлэн мөнгө	56,242.8	321,285.8	265,043.0
Дүн	91,679.7	325,144.6	233,464.9

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 321.3 сая төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд, 3.8 сая төгрөгийг касст бэлэн мөнгөөр байршуулж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд Нийслэлийн ГЗБА-ны он дамжин хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын үлдэгдэл 209.6 сая төгрөгийг барьцааны дансанд байршуулсан, ГЗБГЗЗГ-ын барилгын захиалагчийн техник хяналтын 108.4 сая төгрөгийн зардал хойшлогдсон зэрэг нь нөлөөлсөн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,055.3 сая, эцсийн үлдэгдэл 1,142.8 сая төгрөг болж, 87.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	22,343.9	46,319.6	23,975.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,007,520.8	908,250.8	(99,270.0)

Татаас, санхүүжилтийн авлага	8,000.0	65,428.9	57,428.9
Бусад авлага	17,446.9	122,791.3	105,344.4
Дүн	1,055,311.6	1,142,790.6	87,479.0

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өссөн нь нэмэлт санхүүжилтийн данс дахь Нийслэлийн ГЗБА-ны Мянганы сорилтын сангаас хэрэгжүүлсэн “УБ хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл”-ийн газар чөлөөлөлтийн төлбөр болон 11 аймгийн ГХБХБГ-ын барилгын захиалагчийн техник хяналтын орлогын үлдэгдлийг улсын төсөвт татан авсныг бүртгэснээс шалтгаалжээ.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 40.3 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 449.7 сая төгрөг болж, 409.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төсөвт байгууллага	22,832.3	-	(22,832.3)
Урьдчилж гарсан зардал	17,505.0	449,753.0	432,248.0
Дүн	40,337.3	449,753.0	409,415.6

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал өссөн нь Нийслэлийн ГЗБА-ны хэрэгжүүлсэн 6 төсөл, арга хэмжээг 2022 онд үргэлжлүүлэн хийхээр болсонтой холбоотой байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 36,276.9 сая төгрөг болж, 872.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	25,109,555.0	25,951,916.9	842,361.9
Барилга, байгууламж, орон сууц	8,822,287.6	9,074,595.0	252,307.4
Авто тээврийн хэрэгсэл	3,522,003.5	3,473,215.6	(48,787.9)
Машин тоног төхөөрөмж	10,797,999.7	11,345,427.9	547,428.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,693,492.9	1,758,074.9	64,582.0
Зам, гүүрийн байгууламж	56,215.8	56,215.8	-
Бусад үндсэн хөрөнгө	217,555.6	244,387.8	26,832.2
Биет бус хөрөнгө	10,295,391.9	10,325,042.4	29,650.5
Програм хангамж	996,027.5	995,796.0	(231.5)
Бусад биет бус хөрөнгө	9,299,364.4	9,329,246.4	29,882.0
Дүн	35,404,947.0	36,276,959.3	872,012.4

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 861.1 сая, нэмэлт санхүүжилтийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 532.1 сая, хандиваар хүлээн авсан 429.1 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 302.4 сая, нийт 2,124.7 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 320.9 сая, акталсан 931.7 сая, нийт 1,252.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь барилгын техник хяналтын орлогоос, төслийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн, мөн хөрөнгийг хандиваар болон балансаас балансад үнэ төлбөргүй шилжүүлэн авсан зэрэгтэй холбоотой байна.

3.5.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 19,747.1 сая төгрөг болж, өмнөх оноос 426.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	8,778,951.3	8,791,755.3	12,804.0
Өмч /төрийн/	8,778,951.3	8,791,755.3	12,804.0
Хуримтлагдсан үр дүн	9,654,322.2	10,090,148.0	435,825.8
Өмнөх үеийн үр дүн	9,654,322.2	9,726,382.8	72,060.6
Тайлант үеийн үр дүн	-	363,765.2	363,765.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	887,222.3	865,161.8	(22,060.5)
Дүн	19,320,495.9	19,747,065.2	426,569.3

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 10,090.1 сая төгрөг болж 435.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 363.7 сая төгрөгийн үйл ажиллагааны үр дүнтэй ажилласнаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын бичилт нь Нийслэлийн ГЗБА-ны гэрээт ажлын урьдчилгаа санхүүжилтийн 50.0 сая төгрөгийг 2020 онд олгож, зардалд тусгасныг аудитаар залруулсан, нэр бүхий 12 аймгийн ГХБХБГ-ууд дахин үнэлгээтэй 22.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, өмнөх үеийн үр дүнг бууруулсан зэрэгтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 21,467.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, төслийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 17,626.3 сая төгрөгөөр баталснаас 2021 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 386.9 сая төгрөгөөр буюу 21.9 хувиар бууруулан 17,239.4 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 17,239.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 13,504.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 2,877.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 707.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 150.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 13,368.3 сая, улсын төсвөөс 2,877.1 сая, орон нутгийн төсвөөс 617.1 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 150.0 сая, нийт 17,012.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 17,013.7 сая төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь цар тахлын улмаас албан томилолтын болон зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт дутуу гүйцэтгэлтэй байгаатай холбоотой ба үлдэгдэл 136.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь тайлант онд 2,100.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,895.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 137.8 хувиар биелүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,514.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2,325.0 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 912.2 сая, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 125.3 сая, өмнөх оны үлдэгдэл 129.5 сая, нийт 7,006.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 459.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 4,369.9 сая, тэтгэмж, шагнал урамшуулалд 64.0 сая, хөрөнгийн зардалд 508.1 сая, нийт 5,401.5 сая төгрөгийг зарцуулж, 188.0 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлснийг авлага үүсгэн бүртгэж, үлдэгдэл 1,395.2 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 11,578.9 сая төгрөгийн 350 мэдээлэл байршуулахаас мэдээллийг 100.0 хувь ил тод байршуулснаас 13.5 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

3.7.2 Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалттай холбоотой асуудал

Тайлант онд гүйцэтгэсэн "ОХУ-аас БНХАУ руу Монгол Улсын нутгаар дайран өнгөрөх хий дамжуулах хоолойн трассын нутаг дэвсгэрийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх төсөл"-өөс тухайн ажилд хамааралгүй өрөөний засварын зардалд 22.0 сая төгрөгийг зарцуулж, 31.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн, Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх ..." гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа, зөрчлийг арилгах 50.9 сая төгрөгийн 1 албан шаардлагын биелэлт 95.0 хувь, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийн биелэлт 86.7 хувьтай байна.

Хүснэгт 6. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	50,900.0	1	50,900.0	-	-	95.0
Зөвлөмж	3	96,118.5	2	96,118.5	1		86.7
Дүн	4	147,018.5	3	147,018.5	1	-	90.8

3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын харьяа байгууллагууд барилга байгууламжийн захиалагчийн хяналтын орлого, зардлыг төлөвлөхгүйгээр нэмэлт санхүүжилтийн "Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого" дансанд хүлээн авч зарцуулж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 94.7 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс, 81.2 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 13.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчлийн 81.2 сая төгрөг нь тогтоосон 165.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 84.1 сая төгрөгөөр бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 19 байгууллагад дүгнэлт гаргаж 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 16, “Хязгаарлалттай” 3 дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,726.0 сая төгрөгийн 84 алдаа, зөрчил илрүүлснээс 1,326.0 сая төгрөгийн 31 алдааг аудитын явцад залруулж, 85.5 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 186.4 сая төгрөгийн 18 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 128.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 23 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

4.2 Албан шаардлага

4.2.1 Зардлын данстай холбоотой асуудал

Төсвийн хөрөнгөөр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардалд буюу үндсэн хөрөнгө бэлтгэхэд 12.1 сая, газрын харилцааны албаны тэргүүний ажилтны тэмдэг хэвлүүлэхэд 10.4 сая, нийт 22.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх ..." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4.2.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Газрын кадастрын зураглал хэвлэх үнэт цаасны тендерт Монголын үнэт цаас хэвлэл ХХК шалгарч, нэгжийн үнийг 220.00 төгрөгөөр тогтоон гэрээ байгуулсан боловч нэмэлт гэрээ байгуулан 485.00 төгрөгөөр бүтээгдэхүүн нийлүүлэн 5.3 сая төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1 “захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөх”, Хэвлэлийн ажил гүйцэтгэх 2021/105 дугаар ерөнхий гэрээний 4.1 "Газрын кадастрын зураг хэвлэх үнэт цаасны нэг бүрийн үнэ 220.0 төгрөг" гэж заасныг тус тус мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний холбогдох заалтыг мөрдөж, гэрээгээр нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэхгүй байх, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4.2.3 Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой асуудал

Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохоор гэрээний заалтад тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохгүй байх, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4.3 Зөвлөмж

4.3.1 Харьяа 22 байгууллагын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар

ГЗБГЗЗГ-ын харьяа 22 нэгжийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 271.9 сая төгрөгийн санхүүгийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой материаллаг хэмжээний алдаа зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 "төсвийн төвлөрүүлэн захирагч гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д/д	Ангилал	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн нэр	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
									Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	2	1				1	5	81.2					4	81.2	1	-
Дүн			2	1				1	5	81.2					4	81.2	1	-
1	ТШЗ	Архангай аймгийн ГХБХБГ	1	1					1	4.6					1	4.6		
2	ТШЗ	Баян-Өлгий аймгийн ГХБХБГ	1	1					-	-								
3	ТШЗ	Баянхонгор аймгийн ГХБХБГ	1	1					3	15.9	1	0.2					2	15.7
4	ТШЗ	Булган аймгийн ГХБХБГ	1	1					4	2.7	1	1.0	1	0.8	2	0.9		
5	ТШЗ	Говь-сүмбэр аймгийн ГХБХБГ	1	1					4	7.5	4	7.5						
6	ТШЗ	Дархан-Уул аймгийн ГХБХБГ	1	1					2	635.4	1	621.1					1	14.3
7	ТШЗ	Дорноговь аймгийн ГХБХБГ	1	1					6	261.4	2	209.1			3	52.3	1	-
8	ТШЗ	Дорнод аймгийн ГХБХБГ	1	1					4	1.9			2	1.9			2	-
9	ТШЗ	Дундговь аймгийн ГХБХБГ	1	1					6	18.1	2	5.3	1	0.2	3	12.6		
10	ТШЗ	Завхан аймгийн ГХБХБГ	1	1					5	18.9	3	4.5					2	14.4
11	ТШЗ	Өмнөговь аймгийн ГХБХБГ	1	1					4	38.1	3	36.2					1	1.9
12	ТШЗ	Сэлэнгэ аймгийн ГХБХБГ	1	1					6	21.6	2	5.4	1	0.8			3	15.4
13	ТШЗ	Төв аймгийн ГХБХБГ	1	1					6	131.2	2	112.5	1	2.3	2	16.4	1	-
14	ТШЗ	Ховд аймгийн ГХБХБГ	1	1					3	2.0	2	0.7	1	1.3				
15	ТШЗ	Хэнтий аймгийн ГХБХБГ	1	1					2	22.7	1	14.0			1	8.7		
16	ТШЗ	Нийслэлийн ГЗБА	1	1					3	320.7	2	258.7					1	62.0
17	ТШЗ	Говь-Алтай аймгийн ГХБХБГ	1		1				9	128.3	2	40.5	2	0.9	4	86.9	1	-
18	ТШЗ	Увс аймгийн ГХБХБГ	1		1				5	82.6			3	77.3	1	4.0	1	1.3
19	ТШЗ	Хөвсгөл аймгийн ГХБХБГ	1		1				6	9.3	3	9.3			1	-	2	-
20	ТШЗ	Орхон аймгийн ГХБХБГ	1					1	3	3.1							3	3.1
21	ТШЗ	Өвөрхангай аймгийн ГХБХБГ	1					1	-	-								
22	ТШЗ	Сүхбаатар аймгийн ГХБХБГ	1					1	2	-							2	-
Дүн			22	16	3			3	84	1,726.0	31	1,326.0	12	85.5	18	186.4	23	128.1
Нийт дүн			24	17	3			4	88	1,807.2	31	1,326.0	12	85.5	22	267.6	23	128.1

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д/д	Ангилал	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн нэр	Аудитын санал дүгнэлт					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах			Түүвэрт хамруулсан	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж
								Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	ТТЗ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар						1	13.5					1	13.5		
Дүн								1	13.5					1	13.5		
1	ТШЗ	Архангай						2	10.6					2	10.6		
2	ТШЗ	Дорнод						1	50.0							1	50.0
3	ТШЗ	Өвөрхангай						1	194.9					1	194.9		
4	ТШЗ	Өмнөговь						2	27.3					2	27.3		
5	ТШЗ	Хөвсгөл						1	-					1	-		
Дүн								7	282.8					6	232.8	1	50.0
Нийт дүн								8	296.3					7	246.3	1	50.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 664/А0140066

Улаанбаатар хот

АХТ-2022/01/НА-СТА-ТБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гүйцэтгэсэн "ОХУ-аас БНХАУ руу Монгол Улсын нутгаар дайран өнгөрөх хий дамжуулах хоолойн трассын нутаг дэвсгэрийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх төсөл"-өөс тухайн ажилд хамааралгүй өрөөний засварын зардалд 22,000,000.00 төгрөгийг зарцуулж, 31,428,160.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн, Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх ..." гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, ерөнхий нягтлан бодогч Л.Лувсан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

З.Н. Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

9019120396

"10-10-2020" Инчиг, Khureg, Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-295.Docx

0001081603



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 669/20170066

Улаанбаатар хот

АХТ - 2022/01/48-СТА-ТТЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардалд буюу үндсэн хөрөнгө бэлтгэхэд 12,116,300.00 төгрөг, газрын харилцааны тэргүүний ажилтны тэмдэг хэвлүүлэхэд 10,370,000.00 төгрөг, нийт 22,486,300.00 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх ..." гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, ерөнхий нягтлан бодогч Л.Лувсан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

4006109
10.10.10.20.Bichig_Khereg\Alban_Shuurdлага\2022\0325 Auditin 2 Газар-293.Docx

0001021539



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 25

№ 668/А0170066

Улаанбаатар хот

АХТ - 2022/01/НА - СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын кадастрын зураглал хэвлэх үнэт цаасны тендерт Монголын үнэт цаас хэвлэл ХХК шалгарч нэгжийн үнийг 220.00 төгрөгөөр тогтоон гэрээ байгуулсан боловч нэмэлт гэрээ байгуулан 485.00 төгрөгөөр бүтээгдэхүүн нийлүүлэн 5,307,900.00 төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1 "захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөх", Хэвлэлийн ажил гүйцэтгэх 2021/105 дугаар ерөнхий гэрээний 4.1 "Газрын кадастрын зураг хэвлэх үнэт цаасны нэг бүрийн үнэ 220.0 төгрөг" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний холбогдох заалтыг мөрдөж, гэрээгээр нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэхгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, ерөнхий нягтлан бодогч Л.Лувсан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АУДИТОР

[Signature]

О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Газар-294.Docx

9006109
9019126396

0001081601



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 666 /АД/40066

Улаанбаатар хот

АХС-2022/01/ХА-СТД-ТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохоор гэрээний заалтад тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээт ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, ерөнхий нягтлан бодогч Л.Лувсан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

(Signature)

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АУДИТОР

О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban-Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-296.Docx

0001081605

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for consistent letter formation. There is no text or other markings on the page.

[illegible]